



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 525

Улаанбаатар хот

“Миг даатгал” ХХК-д хувь нийлүүлсэн
хөрөнгийн хэмжээндээ өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны “Даатгалын компанийн дүрмийн сангийн хэмжээг тогтоох тухай” 355 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тус компанийн хувь нийлүүлэгчдээс 750,000,000 /долоон зуун тавин сая/ төгрөгөөр нэмэгдүүлж, дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

	Хувь нийлүүлэгч	Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь /%/
		Эхний үлдэгдэл	Өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	Дашзэвэгийн Зоригт	700,000,000.0	262,500,000.0	962,500,000.0	35.0
2	Жандавын Бат-Орших	280,000,000.0	105,000,000.0	385,000,000.0	14.0
3	Хөхөөгийн Ганбаатар	220,000,000.0	82,500,000.0	302,500,000.0	11.0
4	Ургамалын Бямбасүрэн	220,000,000.0	82,500,000.0	302,500,000.0	11.0
5	Жамбаагийн Өөдөс	200,000,000.0	75,000,000.0	275,000,000.0	10.0
6	Нямсүрэнгийн Энхболд	160,000,000.0	60,000,000.0	220,000,000.0	8.0
7	Ганбатын Батбаяр	100,000,000.0	37,500,000.0	137,500,000.0	5.0
8	Гонгорсүрэнгийн Лхамсүрэн	80,000,000.0	30,000,000.0	110,000,000.0	4.0
9	Лувсангомбын Цэцэг-Эрдэнэ	40,000,000.0	15,000,000.0	55,000,000.0	2.0
	Нийт	2,000,000,000.0	750,000,000.0	2,750,000,000.0	100.0

000887

2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Миг даатгал” ХХК /Ж.Бат-Орших/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

МОНГОЛ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХАМГААГАХ ХЭВЧ